

21 МЕССИАГИЙН Эрх мэдэл ба гайхамшиг

21.1 Сүмийг цэвэрлэнэ.

¹“Харагтун, Би элчээ илгээх гэж байна. Тэр Миний өмнө замыг цэвэрлэх болно. Та нарын хайдаг Эзэн гэнэт Өөрийн сүмд ирэх болно. Тэр ч байтугай та нарын баярлан таашаах гэрээний элч, харагтун, Тэр ирж байна” гэж түмэн цэргийн ЭЗЭН айлдаж байна. “Түмэн цэргийн ЭЗЭН айлдаж байна. (Малахи 3:1 АБ 2004)

⁷Би Өөрийн ариун ууланд аваачин, Өөрийн залбирлын өргөөнд тэднийг баяр хөөртэй болгоно. Тэдний шатаалт тахил, өргөлүүд нь Миний тахилын ширээн дээр тавигдана. Учир нь Миний өргөө бүх ард түмний залбирлын өргөө гэж нэрлэгдэнэ”. (Исаиа 56:7 АБ 2004)

¹²Есүс сүмд орж ирээд худалдаачдыг болон худалдан авагсдыг бүгдийг нь хөөн гаргаж, зоос солигчдын ширээ, тагтаа худалдагсдын сандлыг хөмөрч орхиод, ¹³тэдэнд - “Миний гэр бол залбирлын гэр гэж нэрлэгдэх болно” гэж бичигдсэн байдаг. Гэтэл та нар үүнийг дээрэмчдийн үүр болгож байна. (Матай 21:12-13 АБ 2004)

¹Зовлонтой байсан газар нутагт дахин харанхуй болохгүй. Урьдын цагт Тэр Зебулун болон Нафталийн нутагт жигшүүрээр хандаж байсан бол дараа нь харь үндэстнүүдийн Галил, Иорданы нөгөө талд, тэнгисийн хажуугаар сүр жавхлантай болгоно. ²Харанхуйд алхаж яваа хүмүүс агуу их гэрлийг үзнэ. (Исаиа 9:1-2 АБ 2004)

¹²Есүс Иоханыг баривчлагдсаныг сонсоод, Галил уруу буцлаа. ¹³Тэр Назарыг орхиж, Зебулун болоод Нафталийн мужийн нуурын эрэг дэх Капернаумд ирж суурьшив. ¹⁴Энэ нь эш үзүүлэгч Исаиагаар хэлүүлсэн нь биелэгдсэн бөгөөд “Иорданы чанад тэнгис хүрэх зам дээрх Зебулуны болоод Нафталийн нутаг, харь үндэстнүүдийн Галил, ¹⁶харанхуйд суугч хүмүүс агуу их гэрлийг харж, үхлийн нутагт ба сүүдэрт суугчдын дээр гэрэл тусав” ¹⁷Тэр цагаас эхлэн Есүс -Гэмшицгээ! Тэнгэрийн хаанчлал ойрхон байна гэж тунхаглаж эхлэв. (Матай 4:12-17 АБ 2004)

[] Бурханы сүм нь Бурханд мөргөх, залбирах, уулзах газар юм.

[] Та сүмд мөргөж, залбирахаар очсон уу?

[] Сүмийг юу бузарладгийг та мэдэх үү?

[] Тэргүүнд гүйгчид нь Есүс рүү очих зам руу чиглүүлдэг. Та сайн мэдээний уралдааны сүүлчийн гүйгч үү?

[] Яагаад " Гэмшигтүн" гэсэн үгийг хамгийн эхлээд хэлж байсныг мэдэх үү?

21.2.Шударга ёсыг тунхаглах

• Би бол зөвийг тунхаглагч Бурхан

¹⁸Тэнгэрийг бүтээсэн ЭЗЭН ингэж айлдаж байна. (Тэр бол газрыг бий болгосон Бурхан юм.Тэр газрыг хоосноор бүтээгээгүй бөгөөд хүмүүсийг оршин суулгахын тулд бүтээсэн билээ.) “Би бол ЭЗЭН. Өөр байхгүй. ¹⁹Би харанхуй орны газраас нууцаар яриагүй. “Хоосон газар Намайг хайгтун” гэж Би Иаковын үрд хэлээгүй. ЭЗЭН Би үнэн зөвийг айлдаж байна. Зөв шударга юмсыг тунхаглаж байна. (Исаиа 45:18-19АБ 2004)

¹⁸“Миний сонгосон Зарц, сэтгэлд минь нийцсэн Миний Хайртыг харагтун. Би Түүний дээр Өөрийн Сүнсээ байлгана. Тэр нь харь үндэстэнд шударга ёсыг тунхаглах болно. (Матай 12:18 АБ 2004)

¹⁹Тэргүүн тахилч Есүсээс шавь нарынх нь тухай, мөн сургаалынх нь тухай сууж шалгаав. ²⁰Есүс -Би ертөнцөд ил ярьсан. Би үргэлж бүх иудейчүүдийн цугладаг синагогт болон сүмд сургаал зааж байсан. Би нууцаар юу ч яриагүй. ²¹Та яагаад Надаас асууна вэ? Миний юу ярьсныг сонссон хүмүүсээс асуу. Харагтун, тэд Миний юу ярьсныг мэднэ гэж (Иохан 18:19-21 АБ 2004)

[] Хүмүүс амьдрах хамгийн тохиромжтой орчин болгож энэ дэлхийг бүтээснийг та мэдэх үү?

[] Нүгэл ба шунал нь дэлхийг болон дээрх бүх зүйлийг сүйрүүлж байгааг та мэдэх үү ?

[] Та дэлхийн эцсийн хувь заяаг мэдэх үү?

[] Энэ Дэлхий яагаад Есүсийн үгийг үзэн яддагийг та мэдэх үү?

21.3 Хүмүүсийг эдгээх болно

⁵Тэгээд сохрын нүд нээгдэж, дүлийгийн чих нь онгойно.

⁶Тэгээд доголлон хүн буга мэт дүүлж, хэлгүй нь баяртайгаар хашхирна. Учир нь цөлөөс ус гарч, Арабад урсана. (Исаиа 35:5-6 АБ 2004)

³⁵Есүс синагогуудад сургаал айлдаж, хаанчлалын сайн мэдээг тунхаглан, бүх төрлийн өвчин эмгэгийг эдгээн, бүх хот тосгоноор явж байлаа. (Матай 9:35 АБ 2004)

⁶Тиймд бид зоригтойгоор “Эзэн миний туслагч мөн. Би айхгүй. Хүн намайг яах юм бэ?” (Еврей 13:6 АБ 2004)

¹Иессийн хожуулаас нахиа гарч, үндэснээс нь мөчир ургаж, жимс гаргана. (Исаиа 11:1 АБ 2004)

[] Хэн таньд тусалж байгааг мэдэх үү?

21.4 Булангийн чулуунаас татгалзсан

⁴Эзэн уруу ир. Тэр бол хүмүүст гологдсон боловч, харин Бурханы өмнө сонгогдсон, үнэт, амьд чулуу билээ. ⁵Иймд амьд чулуу мэт болсон та нар ч Есүс Христээр дамжуулан Бурханд тааламжит, сүнслэг тахилуудыг өргөх ариун тахилч болохын тулд сүнслэг байшин болон баригдагтун.

⁶Энэ нь Сударт “Харагтун. Би Сионд сонгогдсон, Булангийн үнэт чулууг тавина. Түүнд итгэгч хүн ичгүүрт орохгүй” ⁷Тиймээс итгэгч та нарт энэ нь үнэт. Харин үл итгэгчдэд “Барилгачдын голсон чулуу нь булангийн чулуу болов” ⁸гээд “Бүдрүүлэх Чулуу, тээглэх Хад болсон юм”(1 Петр 2:4-8 АБ 2004)

[] Та Бурханд таалагдах сүнслэг золиос болж амьдардаг уу?

21.5 МЕССИА: ГАЙХАМШИГ

21.5.1 Усыг дарс болгон хувиргах

¹Гуравдугаар өдөр Галилын Кана хотод нэгэн хурим болоход Есүсийн эх тэнд байв. ²Есүс болон шавь нар нь бас хуриманд уригдсан байлаа. ³Дарс хүрэлцэхгүй болоход Есүсийн эх Түүнд -Тэд дарсгүй болов гэлээ. ⁴Есүс-Эмэгтэй, Надад ч, танд

ч ямар хамаа байна? Миний цаг хараахан болоогүй байна гэжээ. ⁵Эх нь зарц нарт хандан -Тэр та нарт юу гэж айлдана, түүнийг нь хий гэв. ⁶Тэнд хоёр эсвэл гурван метретас багтаамжтай усны зургаан чулуун торх байсан агаад тэдгээрийг иудейчүүдийн ариусгалын ёслолд зориулдаг ажээ. ⁷Есүс тэдэнд -Торхнуудыг усаар дүүргэ гэж айлдсанд тэд торхнуудыг амсарт нь хүртэл дүүргэв. ⁸Есүс-Одоо утгаад найрын ахлагчид аваачиж өг гэсэнд, тэд аваачиж өгөв.

⁹Найрын ахлагч дарс болсон усыг амсаад, тэр дарс хаанаас бий болсныг мэдээгүй учир (харин ус утгасан зарц нар мэдэж байв) шинэ хүргэнийг дуудаж, ¹⁰түүнд -Хүн бүр эхлээд сайн дарсаа гаргаад, хүмүүсийг согтсоны дараа муухнаа гаргадаг. Гэтэл чи сайн дарсаа одоо хүртэл хадгалсан байжээ гэж хэлэв.

¹¹Есүс Өөрийн тэмдгүүдийн эхлэлийг Галилын Кана хотод үйлдэж, алдраа илэрхийлсэнд шавь нар нь Түүнд итгэсэн юм. (Иохан 2:1-11 АБ 2004)

[] Та дуулгавартай байхгүйгээр Их Эзэний гайхамшгуудыг харж чадах уу?

[] Та Их Эзэний баяр баясгаланг эзэмших нууцыг мэдэх үү? Мөн таньд тэрхүү баяр хөөр байгаа юу?

21.5.2 Хоол хүнсийг элбэг болгосон

³³Харин эхлээд Түүний хаанчлал болон Түүний зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно. (Матай 6:33 АБ 2004)

¹Үүний дараа Есүс Галил (буюу Тибер) нуурын нөгөө тал уруу явав. ²Үй олон хүн Түүнийг дагаж байлаа. Учир нь тэд өвчтэй хүмүүст үйлдсэн Түүний тэмдгийг харсан ажээ. ³Есүс уулан дээр гарч, тэнд шавь нарынхаа хамт суув. ⁴Иудейчүүдийн баяр болох Дээгүүр Өнгөрөх баяр ойртсон байлаа.

⁵Есүс харцаа дээшлүүлэн, Өөр уруу нь үй олон хүн ирж буйг хараад, Филипт-Тэднийг хооллох талхыг бид хаанаас худалдаж авах вэ? гэлээ. ⁶Есүс Филиппийг сорихын тулд тийн асуужээ. Учир нь Есүс юу хийхээ Өөрөө мэдэж

байлаа. ⁷Филип Түүнд -Хүн бүр жаахан авлаа ч гэсэн хоёр зуун денарын талх тэдэнд хүрэлцэхгүй шүү дээ гэв.

⁸Шавь нарын нэгэн болох Симон Петрийн дүү Андрей Есүст хандан ⁹-Энд таван арвайн талх, хоёр загастай хүүхэд байна. Гэвч тэр нь энэ олон хүнд юу болох вэ? гэсэнд

¹⁰Есүс -Хүмүүсийг суулга гэв. Тэр газар нь их зүлэгтэй газар бөгөөд таван мянга орчим эрчүүд сууцгаасан байв. ¹¹Тэгээд Есүс талхнуудыг авч, талархал өргөөд, сууцгаасан хүмүүст тарааж өгөв. Мөн загасыг ч тэдний хүссэнээр өгчээ.

¹²Хүмүүс цадсаны дараа Тэр шавь нартаа -Юу ч хаяхгүйн тулд үлдэгдлийг нь цуглуул гэв. ¹³Хүмүүсийг хооллосон таван арвайн талхны үлдэгдлийг тэд цуглуулахад арван хоёр сагс дүүрчээ.

¹⁴Хүмүүс Есүсийн үйлдсэн тэмдгийг үзээд -Ертөнцөд ирэх ёстой өнөөх Эш үзүүлэгч үнэхээр энэ мөн гэж ярилцах болжээ. ¹⁵Тэд ирж, Өөрийг нь хүчлэн хаан болгохыг хүсэж байгааг Есүс мэдээд, зайлж ганцаараа дахин уул уруу явлаа. (Иохан 6:1-15 АБ 2004)

21.5.3 Эдгээх

¹Зэлүүд газар, цөл баярлан, Араба ч баясан, замар цэцэг мэт дэлгэрнэ. ²Энэ нь цэцэглэн сагсайж, цэнгэн баясаж, баяр хөөртэйгөөр хашхирна. Ливаны алдар, Кармел ба Шароны сүр хүч түүнд өгөгдөнө. Тэд ЭЗЭНий алдар, бидний Бурханы цог жавхланг харна.

³Тэнхэлгүй гарыг хүчтэй болгон, суларсан өвдгийг бататгагтун. ⁴Хулчгар зүрхтнүүдэд “Зоригтой бай. Бүү ай. Үзэгтүн, та нарын Бурхан өшөө авахаар ирнэ. Бурхан хариуг нь өгөхийн тулд ирэхдээ та нарыг аварна” гэж хэлэгтүн. ⁵Тэгээд сохрын нүд нээгдэж, дүлийгийн чих нь онгойно. ⁶Тэгээд доголон хүн буга мэт дүүлж, хэлгүй нь баяртайгаар хашхирна.

Учир нь цөлөөс ус гарч, Арабад урсана. ⁷Хатсан газар цөөрөм болж, цангасан газарт ус ундрал, цөөвөр чонын үүр

хоноглох газруудад өвс ургамал хулс, зэгснүүд ургана. (Исаиа 35:1-7 АБ 2004)

²³Есүс бүх Галилаар явахдаа синагогуудад нь сургаал айлдаж, хаанчлалын сайн мэдээг тунхаглаж, олон түмний доторх алив төрлийн өвчин эмгэгийг эдгээж байлаа. ²⁴Түүний тухай зар бүх Сири даяар тархсанд, хүмүүс зовж шаналсан, чөтгөр шүглэсэн, унаж татдаг өвчтэй, саа өвчтэй бүхнийг Түүн дээр авчрахад Есүс тэднийг эдгээжээ. ²⁵Галил, Декаполис, Иерусалим, Иудей түүнчлэн Иорданы тэртээгээс үй олон хүн Түүнийг дагалаа. (Матай 4:23-25 АБ 2004)

[] Итгэлтэй хүмүүсийн хувьд Есүсийн нэрээр мөн адил эдгэрэл бий болох боломжтой гэдэгт та итгэж байна уу?

21.5.4 Сохор

¹Есүс явж өнгөрөхдөө, төрөлхийн сохор хүнийг харжээ. ²Шавь нар нь Түүнээс -Рабби, хэн нүгэл үйлдсэнээс энэ хүн сохор төрсөн юм бэ? Энэ хүн үү? Түүний эцэг эх үү? хэмээн асуусанд ³Есүс -Энэ хүн ч, эцэг эх нь ч нүгэл үйлдсэнээс болоогүй. Харин энэ нь Бурханы ажлуудыг түүгээр харуулахын тулд юм.

⁴Намайг Илгээгчийн ажлыг Би өдөр байхад хийх ёстой. Хэн ч ажиллаж чадахгүй шөнө ирж байна. ⁵Би ертөнцөд байгаа үедээ ертөнцийн гэрэл байна гэж хариулав. ⁶Ингэж хэлээд, Тэр газар нулимж, шүлсээрээ шавар зуурч, тэр хүний нүдийг шавраар шаваад, ⁷-Яв. Силоамын (орчуулбал Илгээгдсэн) цөөрөмд угаа гэж хэлэхэд өнөөх хүн явав. Тэгээд угаагаад, хараатай болон эргэж иржээ.

⁸Урьд түүнийг гуйлгачин байсныг харсан хүмүүс болон хөршүүд нь -Энэ чинь суучихаад гуйлга гуйдаг нөгөө хүн биш үү? гэхэд ⁹зарим нь-Тэр мөн байна гэгцгээв. Бусад нь-Үгүй, түүнтэй төстэй юм байна гэсэнд тэр өөрөө-Тэр чинь би байна гэж хэлэв. ¹⁰Тэд түүнээс -Тэгвэл чиний нүд яаж нээгдсэн юм бэ? гэж асуусанд ¹¹тэр-Есүс гэдэг хүн шавар зуурч, нүдийг минь шаваад, надад “Силоам уруу яваад, угаа” гэж айлдсан. Тэгээд би явж, угаагаад хараатай болсон гэж

хариулав. ¹²Хүмүүс -Тэр хаана байна? гэсэнд өнөөх хүн -Би мэдэхгүй гэлээ. (Иохан 9:1-12 АБ 2004)

³⁵Иудейчүүд тэр хүнийг хөөн гаргасныг Есүс сонсоод, түүнийг олж -Чи Хүний Хүүд итгэж байна уу? гэхэд ³⁶тэр -Эзэн минь, Тэр хэн бэ? Би Түүнд итгэе гэв. ³⁷Есүс -Чи Түүнийг харсан. Одоо чамтай ярьж байгаа нь Тэр мөн гэлээ. ³⁸Тэр -Эзэн минь, би итгэж байна гээд Түүнд мөргөв.

³⁹Есүс түүнд -Би энэ ертөнцөд шүүлтийн төлөө ирсэн нь хардаггүйг хардаг, харагсдыг сохор болгохын тулд юм гэж айлдав. ⁴⁰Фарисайчуудаас Есүстэй хамт байсан хүмүүс эдгээрийг сонсоод, Түүнд -Бид бас сохор юм биш биз? гэхэд ⁴¹Есүс тэдэнд -Хэрэв та нар сохор байсан бол нүгэлгүй байхсан. Гэтэл та нар “Бид харж байна” гэж ярьдаг тул нүгэл чинь байсаар л байна гэлээ. (Иохан 9:35-41 АБ 2004)

[] Та үнэнийг харж байна уу?

21.5.5 Чөтгөр шүглэсэн

²⁸Түүнийг нуурын нөгөө талд гадарчуудын нутагт ирэхэд булшнуудын тэндээс чөтгөрт эзлэгдсэн хоёр хүн гарч ирээд, Түүнтэй тааралдав. Тэд их хэрцгий догшин тул тэр замаар нэг ч хүн явж зүрхэлдэггүй байжээ. ²⁹Үзэгтүн, тэд хашхиран, -Бурханы Хүү, бид Танд ямар хамаатай билээ? Цагаас маань өмнө биднийг тарчилгахаар Та энд ирэв үү? гэв.

³⁰Тэнд тэднээс зайдуухан сүрэг гахай идээшилж байлаа. ³¹Чөтгөрүүд Түүнээс гуйж -Хэрэв Та биднийг хөөж гаргах гэж байгаа бол биднийг сүрэг гахайнд оруулаач гэв. ³²Тэр -Зайлцгаа гэхэд, сүнснүүд гарч гахайнуудад шүглэхэд, гахайн сүрэг бултаараа нуурын эгц эрэг уруу давхилдан орж усанд живж, үхжээ.

³³Гахайчид зугтан хот уруу орж, болсон явдал болоод чөтгөрт эзэмдүүлж байсан хүмүүсийн тухай мэдүүлэв. ³⁴Хотынхон бүгдээрээ Есүстэй уулзахаар ирж, Түүнийг үзээд нутгаасаа явахыг гуйв. (Матай 8:28-34 АБ 2004)

[] Чөтгөрүүд юу хүргэж болохыг та мэдэх үү?

[] Чөтгөрүүд хаашаа явахыг та мэдэх үү?

21.5.6 Хотын гайхамшиг

²⁹Синагогаас гарч ирсний дараа тэр даруй тэд Иаков, Иохан нарын хамт Симон, Андрей хоёрын гэрт очив. ³⁰Симоны хадам эх халуураад хэвтэж байлаа. Тэр даруйд тэд түүний тухай Есүст хэлэхэд ³¹Тэр түүн уруу ирээд гараас нь барин босгоход тэр эмэгтэй халуурахаа болиод, тэдэнд үйлчилжээ. ³²Орой болж, нар жаргасны дараа хүмүүс өвчтэй болон чөтгөр шүгэлсэн бүх хүнийг Түүн уруу авчрав.

³³Хотынхон бүгдээрээ үүдэнд нь цугласан байлаа. ³⁴Есүс төрөл бүрийн өвчтэй олон хүнийг эдгээсэн бөгөөд олон чөтгөрийг зайлуулан, чөтгөрүүдэд ярихыг зөвшөөрсөнгүй. Учир нь тэд Түүнийг хэн болохыг мэдсэн юм. (Марк 1:29-34 АБ 2004)

⁷Есүс шавь нарынхаа хамт нуурын зүг цаашлав. Мөн Галилаас үй олон хүн [дагаж байлаа]. Бас Иудейгээс, ⁸Иерусалимаас, Идумаас, Иорданы тэртээгээс, Тир болон Сидон хавиас үй олон хүн Есүсийн хийсэн бүхнийг сонсоод Түүн уруу иржээ. ⁹Хурсан олонд бүчүүлэхгүйн тулд завь бэлэн байлгахыг Өөрийн шавь нарт Тэр даалгав.

¹⁰Учир нь Есүс олон хүнийг эдгээсэн тул өвчинд зовж зүдрэгсэд бүгд Түүнд гар хүрэх гэж дайрч байлаа. ¹¹Бузар сүнснүүд Есүсийг харах болгондоо өмнө нь унаж, -Та бол Бурханы Хүү мөн гэж хашхиралдаж байв. ¹²Өөрийг нь мэдүүлж болохгүйг Тэр тэдэнд хатуу санууллаа. (Марк 3:7-12 АБ 2004)

[] Тэр таны бүх хэрэгцээг хангаж чадна гэдэгт та итгэдэг үү?

[] Тэр хэрэгцээ нь үүрд мөнх ба Түүний алдарын төлөө юу?

21.5.7 Найзын итгэлээр

¹Хэд хоногийн дараа Есүс Капернаум хотод буцаж ирсэнд, Түүний гэртээ байгаа нь дуулджээ. ²Олон хүн цугларснаас үүд хавиар нь хүртэл зайгүй болжээ. Тэр тэдэнд үг айлдаж байлаа. ³Дөрвөн хүн нэгэн саа өвчтөнийг Түүн уруу авч иржээ.

⁴Цугласан олноос болж Түүнд хүрэх боломжгүй байсан тул тэд Түүний байсан газрынх нь дээврийг хуулж, нүх гаргаад, саа өвчтэй хүнийг дэвсгэртэй нь доош буулгав. ⁵Есүс тэдний итгэлийг хараад, саа өвчтэй хүнд -Хүү минь, нүглүүд чинь уучлагдсан гэв.

⁶Харин тэнд сууж байсан хуулийн багш нарын зарим нь дотроо ⁷-Энэ хүн яаж ингэж ярина вэ? Бурханыг тэр доромжилж байна. Гагцхүү Бурханаас өөр хэн нүглийг уучилж чадах билээ? гэж бодоход

⁸тэр даруй Есүс Өөрийн сүнсээр тэдний бодлыг мэдээд тэдэнд -Яагаад та нар зүрхэндээ тийм юм бодно вэ? ⁹Саа өвчтэй хүнд “Нүгэл чинь уучлагдсан” гэж хэлэх, эсвэл “Бос, дэвсгэрээ аваад яв” гэж хэлэхийн аль нь амархан бэ?

¹⁰Харин Хүний Хүү газар дээр нүглүүдийг уучлах эрх мэдэлтэйг та нарт мэдүүлэхийн тулд гээд Тэрээр саа өвчтэй хүнд ¹¹-Би чамд хэлье. Бос, дэвсгэрээ аваад гэртээ харь гэсэнд ¹²мөнөөх хүн босож, тэр даруй дэвсгэрээ аваад, бүгдийн өмнүүр гарч явлаа. Хүмүүс бүгд мэл гайхаж, - Үүнтэй адил зүйл бид хэзээ ч үзсэнгүй гээд Бурханыг алдаршууллаа. (Марк 2:1-12 АБ 2004)

[] Есүс Христ таны нүглийг харж, уучлах хүчтэй гэдэгт та итгэдэг үү?

[] Итгэлд тань таны бодол төсөөлөл саад болдогийг та мэдэх үү ?

21.5.8 Уяман өвчин

⁴⁰Уяман өвчтэй хүн Түүн уруу ирээд, өмнө нь сөхрөн унаж - Хэрэв Та хүсвэл, намайг цэвэр болгож чадна шүү дээ гэж гуйсанд, ⁴¹Тэр өрөвдөн мутраа сунган, түүнд хүрч -Би хүсэж байна. Цэвэрш гэсэнд ⁴²тэр даруй түүнээс уяман өвчин нь зайлж, тэр цэвэршжээ. ⁴³Тэр түүнд хатуу сануулаад, тэр даруй түүнийг явуулав. ⁴⁴Есүс тэр хүнд -Хэнд ч юу ч ярьж болохгүй. Харин явж тахилчид өөрийгөө үзүүл. Тэдэнд гэрчлэхийн тулд цэвэршсэнийхээ төлөө Мосегийн тогтоосон өргөлийг өргө гэж айлдав.

⁴⁵Гэтэл тэр гараад болсон бүхнийг ярин зарлаж эхэлсэн ба үүнээс болоод Есүс хотод илээр явах боломжгүй болж, хүнгүй газруудад байх болов. Харин зүг бүрээс хүмүүс Түүнийг зорин ирсээр байлаа. (Марк 1:40-45 АБ 2004)

[] Есүсийн эдгээх гарт хүрэхийг хүсч байна уу?

[] Тэр яагаад уяман өвчтэй хүнд хүрснийг та мэдэх үү?

21.5.9 Халууралт

¹⁴Есүс Петрийн гэрт очиж, хадам эхийг нь халуунтай өвдөн хэвтэж байхыг харав. ¹⁵Есүс түүний гарт хүрэхэд халуун нь арилан, тэр босоод Түүнд үйлчлэв.

¹⁶Орой болоход тэд чөтгөр шүглэсэн олон хүнийг Түүн уруу авчрахад, Есүс сүнснүүдийг үгээр хөөн зайлуулж, өвдсөн бүгдийг эдгээжээ. ¹⁷Энэ нь эш үзүүлэгч Исаиагаар “Бидний сул дорой байдлыг Тэр Өөртөө авч, бидний өвчнийг үүрсэн” гэж хэлүүлсэн нь биелэхийн тулд байлаа. (Матай 8:14 -17 АБ 2004)

[] Их Эзэнийг урьж, түүнтэй хамт алх. Таньд юу хэрэгтэйг тэр мэддэг гэдэгт та итгэдэг үү?

21.5.10 38 жилийн турш тахир дутуу

¹⁴Бид Кадеш-барнеагаас хөдлөөд Зеред горхийг гаталсан үе хүртэл буюу ЭЗЭНий тэдэнд тангарагласан ёсоор тэр үеийн

дайчид бүгдээрээ хуарандаа сөнөх хүртэл гучин найман жил өнгөрчээ. (Дэд хууль 2-14 АБ 2004)

¹Үүний дараа нь иудейчүүдийн нэгэн баяр болж байхад нь Есүс Иерусалим уруу очив. ²Иерусалимын хонины хаалганы дэргэд еврейгээр Бетзада гэдэг цөөрөм байдаг. Тэнд таван саравч байдаг бөгөөд ³тэдгээрийн дотор өвчтэй, сохор, доголлон, хатангир олон хүн хэвтэж байлаа. [Тэд ус хөдлөхийг хүлээж байв. ⁴Учир нь Эзэний тэнгэр элч тодорхой үед цөөрөмд бууж, усыг хөдөлгөхөд, ус хөдөлсний дараа түрүүлж орсон хүн ямар ч өвчнөөр өвчилсэн байлаа ч өвчнөөсөө ангижирдаг байжээ.]

⁵Гучин найман жил өвчтэй байсан нэгэн хүн тэнд байв. ⁶Тэнд хэвтэж буй түүнийг Есүс харж, удаан хугацаагаар тийм байсныг нь мэдээд, түүнээс-Чи эрүүл болохыг хүсэж байна уу? гэж асуухад ⁷мөнөөх өвчтэй хүн-Эзэн, ус хөдлөх үед намайг цөөрөмд оруулах хүн байдаггүй. Харин намайг очсоор байтал өөр хүн надаас өмнө орчихдог гэсэнд ⁸Есүс түүнд -Бос. Дэвсгэрээ аваад, яв гэж айлдав. ⁹Өнөөх хүн тэр даруй эрүүл болж, дэвсгэрээ аваад явав. Тэр өдөр Амралтын өдөр байлаа. ¹⁰Тиймээс иудейчүүд мөнөөх эдгээгдсэн хүн - Өнөөдөр Амралтын өдөр, та дэвсгэрээ авч явж болохгүй гэжээ. ¹¹Харин тэр тэдэнд -Намайг эдгээсэн нэгэн надад “Дэвсгэрээ аваад, яв” гэсэн гэж хариулахад, ¹²тэд -“Дэвсгэрээ аваад, яв” гэж хэн танд хэлсэн бэ? гэж шалгаав. ¹³Гэвч мөнөөх эдгээгдсэн хүн Түүнийг хэн байсныг мэдээгүй юм. Учир нь тэр газарт олон хүн байсан тул Есүс зайлан явсан байлаа. ¹⁴Дараа нь Есүс түүнийг сүмд олоод -Харагтун, чи эрүүл болжээ. Чамд илүү муу юм тохиолдохгүйн тулд дахиж нүгэл бүү үйлд гэв. ¹⁵Тэр хүн иудейчүүд дээр очиж, өөрийг нь эдгээсэн хүн Есүс болохыг тэдэнд хэллээ. (Иохан 5:1-15 АБ 2004)

Эдгэрэлт: Дахин нүгэл бүү үйлд, эс тэгвээс Цөөрөмд орохын төлөө 38 жил хүлээсэн саа өвчтэй хүнд тохиолдсон шиг саар нь ирж магад.

Итгэлгүй: Египетийн боолчлолоос гараад израильчууд 38 жилийн турш тэнүүчилсэн ; Тэд бүгд цөлд үхсэн.

[] Цөл дэхь 38 жилийн тэнүүчлэл , 38 жилийн турш байсан тахир дутууг эдгээсэн гайхамшгуудын аль нь ч хүмүүсийг БИ БОЛ НЬ хэн болохыг мэдэхэд хүргээгүй. Яагаад гэдгийг та мэдэх үү?

[] ҮГЭНД итгэснээр гайхамшгуудыг бий болох боломжтой гэдэгт та итгэдэг үү?

21.5.11 Усыг захирах хүч

¹⁶Орой болоход шавь нар нь нуурын зүг буугаад, ¹⁷завинд сууцгаасны дараа, нуурыг гатлан Капернаумыг зүглэв. Хэдийн харанхуй болсон авч Есүс тэдэн уруу ирээгүй л байлаа. ¹⁸Хүчтэй салхинаас болж нуур давалгаалж эхлэв. ¹⁹Шавь нар нь хорин тав эсвэл гучин стадиа орчим газар сэлүүрдээд байтал Есүс нууран дээгүүр алхан, завь уруу нь дөхөхийг хараад тэд айцгаалаа. ²⁰Гэвч Есүс тэдэнд -Би байна. Бүү ай! гэж айлдав.

²¹Тэд Есүсийг завиндаа оруулахыг хүсжээ. Тэр даруй завь нь очих газартаа хүрсэн байлаа. (Иохан 6:16-21 АБ 2004)

[] Амьдралын жинхэнэ бэрхшээлүүд нь хэцүү асуудлаас биш харин итгэлгүй байдлаас үүдэлтэй байдаг. Асуудлаа дийлж гарсан итгэл танд байна уу? Та хэрэгцээгээ хангахын тулд Есүсийг хайдаг уу?

21.5.12 Салхины хүч

²³Түүнийг завинд суухад шавь нар нь Түүнийг дагалаа. ²⁴Үзэгтүн. Нуурт маш хүчтэй шуурга босож, завь давалгаанд автсан боловч Есүс унтаж байлаа. ²⁵Тэд Түүн уруу ирж, Түүнийг сэрээгээд -Эзэн минь, авраач, бид сүйрлээ гэхэд нь, ²⁶Есүс тэдэнд -Юунд айцгаана вэ, итгэл багатай хүмүүс ээ? гээд Тэр босож, салхи болоод нуурыг зэмлэжээ. Гэтэл нам гүм боллоо.

²⁷Хүмүүс гайхаж -Энэ ер нь ямар янзын хүн болоод салхи, нуур хүртэл Түүнд захирагдаж байгаа юм бэ? гэлцэв. (Матай 8:23-27 АБ 2004)

[] Та Бурханыг эрэлхийлж, амьдралын шуурган дунд ч итгэлээрээ хүчтэй хэвээрээ байна уу?

21.6 Нигүүлслийн цагийг эхлүүлсэн: Сүм